



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/585

Номгон

Австралийн Элчин сайдын яамны төлөөлөл,  
АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд  
Бүрэн эрхт Элчин сайд нарын албан айлчлалд  
хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, "Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр хэсгийн 4.2.8, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар хэсгийн 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийг танилцуулах Австралийн Элчин сайдын яамны төлөөлөл, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд нарын албан айлчлалыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Баянмөнх)-д үүрэг болгосугай.

2. Айлчлалын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Айлчлалтай холбоотой мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, архивын материал бүрдүүлэх ажлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Баянмөнх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлого хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210371